



2019 оны 01 дүгээр сарын 28  
№04/1057/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын  
хууль**

**Монгол Улсын Их Хурлын  
чуулганы хуралдааны дэгийн  
тухай хуульд нэмэлт  
оруулах тухай**

**Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол**

**Монгол Улсын Засгийн  
газрын гишүүнийг  
томилох тухай**

**Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол**

**Жагсаалт, журам  
шинэчлэн батлах тухай**

**ГАРЧИГ**  
**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

- |     |   |    |
|-----|---|----|
| 16. | Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 82 |
| 17. | Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай                  | 82 |

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

- |     |  |                 |
|-----|--|-----------------|
| 18. | Б.Ундармаагийн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай | Дугаар 01<br>83 |
| 19. | Л.Энхболдын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай    | Дугаар 02<br>83 |
| 20. | Д.Дамба-Очирын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай | Дугаар 03<br>84 |
| 21. | Г.Солтаны Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай      | Дугаар 04<br>84 |
| 22. | Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай  | Дугаар 05<br>85 |
| 23. | Тогтоолын төсөл буцаах тухай   | Дугаар 06<br>85 |

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

- |     |                                       |                  |
|-----|---------------------------------------|------------------|
| 24. | Жагсаалт, журам шинэчлэн батлах тухай | Дугаар 291<br>86 |
|-----|---------------------------------------|------------------|

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН  
ЦЭЦИЙН ТОГТООЛ**

- |     |   |                  |
|-----|---|------------------|
| 25. | Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсгийн зохицуулалтаар Цэцийн 2010 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болсон хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх маргааныг эцэслэн хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 01<br>108 |
|-----|---|------------------|



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 01 дүгээр  
сарын 18-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16<sup>1</sup> дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 16<sup>1.3</sup> дахь хэсэг нэмсүгэй:

“16<sup>1.3</sup>. Улсын Их Хурлын гишүүдийн олонх Улсын Их Хурлын даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай саналыг Улсын Их Хуралд албан ёсоор тавьж, тогтоолын төсөл өргөн мэдүүлсэн бол төслийг энэ хуулийн 16<sup>1.1</sup>, 16<sup>1.2</sup>-т заасан журмын дагуу хэлэлцүүлнэ.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 01 дүгээр  
сарын 18-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 10.2.6 дахь заалт нэмсүгэй:

“10.2.6. Улсын Их Хурлын гишүүдийн олонх Улсын Их Хурлын даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай саналыг албан ёсоор тавьж, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Улсын Их Хурал хэлэлцэн ёсоор болгосон.”

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “10.2.3-т” гэснийг “10.2.3, 10.2.6-д” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 01 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

### **Б.Ундармаагийн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Батбаярын Ундармаагийн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх шаардлагагүй гэж үзсүгэй.

2.Энэ тогтоолыг 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 01 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 02

Улаанбаатар  
хот

### **Л.Энхболдын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Лувсангийн Энхболдын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх шаардлагагүй гэж үзсүгэй.

2.Энэ тогтоолыг 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 01 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 03

Улаанбаатар  
хот

### **Д.Дамба-Очирын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дорждамбын Дамба-Очирын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх шаардлагагүй гэж үзсүгэй.

2.Энэ тогтоолыг 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 01 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар  
хот

### **Г.Солтаны Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Гомбожайн Солтаны Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх шаардлагагүй гэж үзсүгэй.

2.Энэ тогтоолыг 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 01 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 05

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар Чүлтэмийн Улааныг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 01 дүгээр  
сарын 17-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар  
хот

### Тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр нарын 9 гишүүнээс 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Түр хороо байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 10 дугаар  
сарын 03-ны өдөр

Дугаар 291

Улаанбаатар  
хот

### Жагсаалт, журам шинэчлэн батлах тухай

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт”-ыг 1 дүгээр, “Тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэх журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2003 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 222 дугаар тогтоол, “Стандартчилал, тохирлын үнэлгээний ажлыг боловсронгуй болгох зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2005 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 127 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолыг 2018 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД**

**Ө.ЭНХТҮВШИН**

Засгийн газрын 2018 оны 291 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

### ТОХИРЛЫН БАТАЛГААНД ЗААВАЛ ХАМРУУЛАХ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Бүлэг	Зүйл	Барааны ерөнхий нэршил
1	2	3
А. БАТАЛГААЖУУЛАЛТАД ХАМРУУЛАХ БҮТЭЭГДЭХҮҮН		
АМЬД МАЛ, АМЬТАД; МАЛ, АМЬТНЫ ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН		
04	04.01	Саахар болон бусад амтлагчийн хольцгүй шингэн сүү, цөцгий
	04.02	Саахар болон бусад амтлагчийн хольцтой, өтгөрүүлсэн сүү, цөцгий



	04.03	Саахар, эсвэл бусад чихэрлэг амтлагч, үнэр оруулагч, жимс, самар, эсвэл какаоны хольцтой, эсвэл хольцгүй, өтгөрүүлсэн, эсвэл өтгөрүүлээгүй зөөхий, иогурт, тараг, хоормог, ферментжүүлсэн, эсвэл исгэсэн бусад сүү болон цэцгий (зүйл 0403.90-д заасан айрагнаас бусад хамаарна)
	04.05	Цэцгийн тос, сүүнээс гаргаж авсан бусад өөх тос, өтгөн цэцгий
	04.06	Бяслаг ба аарц
	04.09	Зөгийн цэвэр бал
05	05.04	Мал, амьтны (загаснаас бусад) шинэ, хөргөсөн, хөлдөөсөн, давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан, утсан бүтэн, эсвэл хэсэглэсэн өлөн гэдэс (зүйл 0504.00-д заасан мал, амьтны давсаг, гүзээнээс бусад хамаарна)
УРГАМЛЫН ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН		
09	09.01	Хуурсан, эсвэл хуураагүй, кофеиноос цэвэрлэсэн буюу цэвэрлээгүй кофе; кофены хальс, яс; тодорхой хэмжээний кофены агуулгатай кофег орлодог бүтээгдэхүүн
	09.02	Амт, үнэр оруулсан, эсвэл оруулаагүй цай
	09.04	Хатаасан буталсан, нунтагласан чинжүү
	09.05	Ваниль
10	10.06	Цагаан будаа
	10.08	Гурвалжин будаа, шар будаа (зүйл 10.08-д заасан канарын үр, бусад үр тарианаас бусад хамаарна)
11	11.01	Улаанбуудайн, эсвэл улаанбуудай-хөх тарианы гурил
	11.02	Улаанбуудай, улаанбуудай-хөх тарианаас бусад үр тарианы гурил
	11.08	Цардуул; инулин
15	15.09	Чидун жимсний цэвэршүүлсэн, эсвэл цэвэршүүлээгүй, гэхдээ химийн хувиргалт хийгээгүй тос, түүний фракц
	15.10	Чидун жимснээс гаргаж авсан, цэвэршүүлсэн, эсвэл цэвэршүүлээгүй, гэхдээ химийн хувиргалт хийгээгүй бусад тос, тэдгээрийн фракц (зүйл 15.09-д заасан тос, фракцтай эдгээрийг хольсон хольц, эсвэл фракц хамаарна)





	15.11	Дал модны цэвэршүүлсэн, эсвэл цэвэршүүлээгүй, гэхдээ химийн хувиргалт хийгээгүй тос, түүний фракц
	15.12	Наранцэцгийн үр, мөнхцэцэг, хөвөнгийн үрийн цэвэршүүлсэн, эсвэл цэвэршүүлээгүй, гэхдээ химийн хувиргалт хийгээгүй тос, тэдгээрийн фракц
	15.13	Наргил модны самар, дал модны самрын, эсвэл бабасугийн цэвэршүүлсэн, эсвэл цэвэршүүлээгүй, гэхдээ химийн хувиргалт хийгээгүй тос, тэдгээрийн фракц
	15.14	Рапс, шаармаг, эсвэл гичийн цэвэршүүлсэн, эсвэл цэвэршүүлээгүй, гэхдээ химийн хувиргалт хийгээгүй тос, тэдгээрийн фракц
	15.15	Бусад ургамлын гаралтай цэвэршүүлсэн, эсвэл цэвэршүүлээгүй, гэхдээ химийн хувиргалтад хийгээгүй урсамтгай бус тос, (жожоба тос орно) болон тэдгээрийн фракц
<b>ХҮНСНИЙ БЭЛЭН БҮТЭЭГДЭХҮҮН; СОГТУУРУУЛАХ БОЛОН СОГТУУРУУЛАХ БУС УНДАА, ЦУУ; ТАМХИ БОЛОН ТАМХИ ОРЛУУЛАГЧ</b>		
16	16.01	Мах, дайвар мах, эсвэл цусаар хийсэн хиам болон түүнтэй төстэй бүтээгдэхүүн; тэдгээрээр хийсэн хүнсний бэлдмэл
	16.02	Мах, дайвар мах, эсвэл цусаар хийж бэлтгэсэн, эсвэл нөөшилсөн бусад бүтээгдэхүүн
	16.04	Загасны бэлэн, эсвэл нөөшилсэн бүтээгдэхүүн; загасны өндгөөр бэлтгэсэн түрс, түрс орлуулагч
	16.05	Хавч, нялцгай биетэн болон усны сээр нуруугүй бусад амьтдаар бэлтгэсэн, эсвэл нөөшилсөн бүтээгдэхүүн
17	17.01	Чихрийн нишингийн, эсвэл чихрийн манжингийн саахар, хатуу төлөв байдалтай химийн цэвэр сахароз
	17.04	Найрлаганд нь какао агуулагдаагүй саахран бүтээгдэхүүн (цагаан шоколад орно) (зүйл 17.04-т заасан саахраар бүрсэн, эсвэл бүрээгүй бохьноос бусад хамаарна)
19	19.02	Чанасан, эсвэл чанаагүй, хавчуургатай (мах, бусад зүйлсийн) буюу хавчуургагүй, эсвэл бусад байдлаар бэлтгэсэн шпагетти, хөндий, дун болон хэрчмэл гоймон, клецки, банш, атриат хөндий гоймон зэрэг гоймонгийн зүйлс; хэрэглэхэд бэлэн, эсвэл бэлэн бус кускус
	19.03	Тапиока, түүнийг орлох нэвс, үрэл, лавс, шигшдэс, эсвэл тэдгээртэй төстэй хэлбэрийн цардуулан бэлдмэл (зүйл 19.03-т заасан пүнтүүз хамаарна)



	19.05	Какаоны найрлагатай, эсвэл найрлагагүй талх, нарийн боов, бялуу, жигнэмэг болон бусад гурилан бүтээгдэхүүн; энгийн өрмөнцөр, эм савлах зориулалттай хөндий бортого, өнгөлөх өрмөнцөр, тутраган цаас болон тэдгээртэй төстэй бүтээгдэхүүн
20	20.06	Саахранд нөөшилсөн (нэвчүүлсэн, бүрсэн, түрхсэн) хүнсний ногоо, жимс, самар, жимсний хальс болон ургамлын бусад эд хэсэг
	20.07	Саахар, эсвэл бусад амтлагч нэмж, эсвэл нэмэхгүйгээр болгож бэлтгэсэн жимсний чанамал, жимсний цэлцгий (желе), мармелад, жимс, эсвэл самрын нухаш (пюре), жимс, эсвэл самрын зуурмаг
	20.08	Бусад аргаар бэлтгэсэн, эсвэл нөөшилсөн, саахар, эсвэл бусад амтлагчийн, эсвэл спиртийн хольцтой, хольцгүй, бусад газар заагдаагүй жимс, самар болон ургамлын хүнсэнд хэрэглэх бусад эд хэсэг
	20.09	Саахар болон бусад амтлагчийн нэмэлт хольцтой, эсвэл хольцгүй, исгээгүй, спиртийн хольцгүй жимс, ногооны шүүс (түүнчлэн усан үзмийн өтгөн шүүс орно)
21	21.03	Сүмс болон сүмс бэлтгэх бүтээгдэхүүн; амтлагчийн холимог бэлдмэл; нунтаг гич болон гичний бэлдмэл
	21.04	Шелтэй бэлэн хоол, эсвэл тунгалаг шөл, тэдгээрийг хийх бэлдмэл; нэгэн төрлийн болгосон хүнсний холимог бэлдмэл
	21.05	Какао агуулсан, эсвэл агуулаагүй зайрмаг, хүнсний зориулалтын бусад хөлдөөсөн бүтээгдэхүүн
22	22.01	Саахар, эсвэл амт, үнэр оруулагч бусад бодисын хольцгүй ус, байгалийн, эсвэл хиймэл рашаан, хийжүүлсэн ус; мөс болон цас
	22.02	Саахар, эсвэл амт, үнэр оруулагч бусад бодисын хольцтой ус, байгалийн, эсвэл хиймэл рашаан, хийжүүлсэн ус болон зүйл 20.09-д заагдсан жимс, ногооны шүүснээс бусад согтууруулах бус ундаа
	22.03	Амуугаар исгэсэн шар айраг
	22.04	Усан үзмийн цэвэр дарс (түүнчлэн спиртээр хатууруулсан дарс орно); усан үзмийн зүйлийн 20.09-д заагдсанаас бусад шүүс



	22.05	Вермут болон ургамлын ханд, эсвэл амт, үнэр оруулагч бодис нэмсэн усан үзмийн бусад цэвэр дарс
	22.06	Исгэсэн бусад ундаа (жишээ нь: алимны, лийрийн, зөгийн балны исгэсэн ундаа, сакэ); бусад газар заагдаагүй, исгэсэн ундаануудын хольц, исгэсэн ундаа болон согтууруулах биш ундааны хольц
	22.07	80%, эсвэл түүнээс дээш хатуулагтай этилийн хувилаагүй спирт; ямар ч хатуулагтай байж болох этилийн хувилсан спирт болон бусад спирт
	22.08	80%-иас бага хатуулагтай, этилийн хувилаагүй спирт; архины зүйлс, ликёр болон спиртлэг бусад ундаа
	22.09	Цуу, цууны хүчлээс гаргаж авсан цуу орлуулагч
24	24.02	Тамхи, эсвэл тамхи орлуулагч агуулсан сигар, үзүүрийг нь тайрсан сигар (cheroots), нарийн ороосон сигар (сигарилл) болон янжуур
	24.03	Боловсруулсан бусад тамхи болон тамхи орлуулагч; "нэгэн төрлийн болгосон" буюу "сэлбэгдсэн" тамхи; тамхины ханд болон охь (зүйл 2403.19-д заасан гаансаар татах зориулалттай дүнсэн тамхи хамаарна)
<b>ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮН</b>		
25	25.01	Тоосжилтийг дарах, бөөгнөрөлтөөс хамгаалах бодис нэмсэн, эсвэл нэмээгүй, усанд уусгасан буюу уусгаагүй давс (хүнсний болон хүнсний биш), цэвэр хлорт натри; далайн шорвог ус (зүйл 2501.00-д заасан хүнсний болон иоджуулсан давс орно)
	25.12	Хувийн жин нь 1 буюу түүнээс бага байх, шатаасан, эсвэл шатаагаагүй, цахиурлаг шороон эрдэс (жишээлбэл: кизельгур, триполит, диатомит ) болон түүнтэй төстэй цахиурлаг эрдэс
	25.17	Барилгын ажилд хэрэглэх хайрга, дайрга, элс хайрганы хольц
	25.23	Өнгө оруулсан, эсвэл оруулаагүй, клинкер хэлбэрт оруулсан буюу оруулаагүй, портланд цемент, пуйлсаган цемент /хөнгөн цагаант цемент/, шаарган цемент, суперсульфатын цемент болон тэдгээртэй төстэй усжсан цемент



	25.29	Хээрийн жонш; цанар (лейцит), мана (нефелин) болон манат таланс (нефелин-сиенит); хайлуур жонш (зүйл 2529.21-д заасан хайлуур жонш, 2529.22-т заасан хайлуур жоншны баяжмал хамаарна)
26	26.01	Төмрийн хүдэр болон баяжмал (зүйл 2601.11-д заасан төмрийн баяжмал хамаарна)
	26.03	Зэсийн хүдэр болон баяжмал (зүйл 2603.00-д заасан зэсийн баяжмал хамаарна)
	26.04	Никелийн хүдэр болон баяжмал (зүйл 2604.00-д заасан никелийн баяжмал хамаарна)
	26.08	Цайрын хүдэр болон баяжмал (зүйл 2608.00-д заасан цайрын баяжмал хамаарна)
	26.09	Цагаан тугалганы хүдэр болон баяжмал (зүйл 2609.00-д заасан цагаан тугалганы баяжмал орно)
	26.11	Гянтболдын хүдэр болон баяжмал (зүйл 2611.00-д заасан гянтболдын баяжмал орно)
	26.13	Молибдены хүдэр болон баяжмал (зүйл 2613.10-т заасан улайсган боловсруулсан молибдены баяжмал, 2613.90-д заасан улайсган боловсруулснаас бусад молибедыны баяжмал хамаарна)
	26.16	Үнэт металлын хүдэр болон баяжмал (зүйл 2616.10-т заасан мөнгөний баяжмал хамаарна)
27	27.10	Нефтийн тос болон битумжсан эрдсээс гаргаж авсан тос, нефтийн бүтээгдэхүүн (түүхий нефть, газрын түүхий тосноос бусад); жингийн 70 % буюу түүнээс дээш хэсэгт нефтийн тос, эсвэл битумжсан эрдсээс гаргаж авсан тос агуулсан, бусад газар заагдаагүй бэлдмэл (эдгээр тос нь бэлдмэлийн үндсэн бүрдүүлэгч хэсэг нь байна) хаягдал тос орохгүй
	27.11	Нефтийн хий болон хийн байдалтай бусад нүүрс устөрөгч (зүйл 2711.11, 2711.21-д заасан байгалийн хийнээс бусад хамаарна)
ХИМИЙН БОЛОН ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН		
32	32.08	Нийлэг, эсвэл байгалийн хувиргасан полимерт суурилсан, усан биш орчинд уусгасан буюу булингажуулсан найруулсан будаг, лак (чий) (пааландах будаг, эсвэл маажин орно); энэ бүлгийн 4 дүгээр тайлбарт заасан уусмал



	32.09	Нийлэг, эсвэл байгалийн хувиргасан полимерт суурилсан, усан орчинд уусгасан буюу булингажуулсан найруулсан будаг, лак (чий) (пааландах будаг, маажиндах чий орно)
	32.10	Бусад найруулсан будаг болон лак (чий) (пааландах будаг, маажин, цавуут будаг орно); арьс ширэн эдлэлийн өнгө заслын зориулалттай бэлдмэл усан нөсөө
	32.11	Хаталтыг хурдасгагч бэлдмэл (зүйл 32.11-д заасан олиф орно)
	32.14	Шилний шаваас, ургамлын иш, мөчир зэргийг залган ургуулахад ашигладаг шаваас, давирхайт цемент, шавах зориулалтын бусад бэлдмэл; зураачийн шаваас; барилгын нүүрэн тал, дотор хана, шал, тааз зэргийн гадаргуугийн засал хийх галд тэсвэргүй бэлдмэл (зүйл 32.14.90-д заасан бусад гэсэн хэсэгт барилгын ажилд хэрэглэх өнгөлгөөний замаска, магни барьцалдуулагчтай керамик түрхлэг, магни барьцалдуулагчтай хуурай хольц, дулаан тусгаарлах шингэн керамик түрхлэг хамаарна)
33	33.03	Үнэртэй ус, ариун цэврийн ус
	33.04	Гоо сайхны бэлдмэл, эсвэл нүүр будалт хийх бэлдмэл, биеийн арьс арчилж, хамгаалах бэлдмэл (эмийн бэлдмэлээс бусад наранд шарах болон нарнаас хамгаалах бэлдмэл орно); гар, хөлийн хумс заслын бэлдмэл
	33.05	Үс арчлах бэлдмэл
	33.06	Амны хөндий, шүдний ариун цэврийн бэлдмэл, хиймэл шүд бэхжүүлэх нунтаг, шахмал оо; жижиглэн худалдаалах нэг бүрийн боодолтой шүдний мяндсан чигчлүүр
34	34.01	Саван; саван болгон хэрэглэдэг, цувимал, зүсмэл хэлбэр, эсвэл хэвэнд оруулсан, саван агуулсан буюу агуулаагүй гадаргуугийн идэвхт органик бүтээгдэхүүн болон бэлдмэл; саван агуулсан, эсвэл агуулаагүй жижиглэн худалдаалах зориулалтаар савласан, арьс шир угаах зориулалттай, шингэн, эсвэл тосон төлөвтэй гадаргуугийн идэвхт органик бүтээгдэхүүн болон бэлдмэл; саван буюу угаалгын бодисоор нэвчүүлсэн, хучсан, эсвэл бүрсэн цаас, хөвөн, эсгий болон нэхээсгүй материал (3401.30-д заасан саван агуулсан, эсвэл агуулаагүй, жижиглэн худалдаалах зориулалтаар савласан, шингэн буюу тосон төлөвтэй, арьс угаах зориулалттай, гадаргуугийн идэвхт органик бүтээгдэхүүн болон бэлдмэлээс бусад хамаарна)



	34.02	Гадаргуугийн идэвхт органик бодис (савангаас бусад); зүйл 34.01-д зааснаас бусад, саван агуулсан, эсвэл агуулаагүй гадаргуугийн идэвхт бэлдмэл, угаалгын бэлдмэл (туслах чанарын угаалгын бэлдмэл орно) болон цэвэрлэгээний бэлдмэл
	34.04	Хиймэл болон бэлтгэсэн лав
35	35.05	Декстрин болон хувиргасан бусад цардуул (жишээ нь: цэлцгийрүүлсэн, эсвэл эфиржүүлсэн цардуул); цардуул, декстрин буюу хувиргасан бусад цардуулд суурилсан цавуу (зүйл 3505.20-д заасан цавуу хамаарна)
	35.06	Бусад газар заагдаагүй бэлэн цавуу болон цавуулаг бодис; жижиглэн худалдаалах зорилгоор цэвэр жин нь 1 кг-аас ихгүй байхаар савласан цавуу болон цавуулаг зүйлс (зүйл 3506.10-д заасан жижиглэн худалдаалах зорилгоор цэвэр жин нь 1 кг-аас ихгүй байхаар савласан цавуу болон цавуулаг зүйлс хамаарна)
36	36.01	Дарь, тийрэлтэт түлш
	36.02	Дарь, тийрэлтэт түлшнээс бусад тэсрэгч бэлдмэл
	36.03	Гал дамжуулах аюулгүй утас; тэсэлгээний утас; цохилтын, эсвэл тэсэлгээний бялтат бүрхүүл; ноцоогуур; цахилгаан тэслүүр
	36.04	Гэрэлтэн шатагч зүйлс, дохионы гэрэлт болон борооны пуужин, аадар эсэргүүцэх, манантай үеийн дохиоллын пуужин, пиротехникийн бусад хэрэгсэл
38	38.24	Цутгамлын хэв, эсвэл тольт хийх зориулалтын холбогч бэлдмэл; химийн буюу түүнтэй төстэй үйлдвэрийн бусад газар заагдаагүй бүтээгдэхүүн болон бэлдмэл (байгалийн гаралтай бүтээгдэхүүний хольц агуулсан бүтээгдэхүүн орно). (зүйл 3824.10-т заасан цутгамлын хэв, эсвэл гол, тольт хийх зориулалтын холбогч бэлдмэл, 3824.30-д заасан металлын холбогч агуулсан болон хамтад нь хольсон, шахаж бөөгнөрүүлээгүй металлын карбид, 3824.40-д заасан цемент, зуурмаг, бетоны нэмэлт материал хамаарна)



ХУВАНЦАР БОЛОН ТҮҮГЭЭР ХИЙСЭН ЗҮЙЛС; ХАЙМАР (КАУЧУК) БОЛОН ТҮҮГЭЭР ХИЙСЭН ЗҮЙЛС		
39	39.09	Анхдагч төлөвт байгаа амины давирхай, фенолын давирхай болон полиуретан (зүйл 3909.50-д заасан полиуретан хамаарна)
	39.17	Хуванцар гуурс, хоолой, шланг, тэдгээрийн холбоос (жишээлбэл: муфт, тахир болон нударган холбоос)
	39.18	Шалны уян хулдаас. Нэг төрлийн үет болон олон төрлийн үет шалны (PVC) болон бусад хулдаас
	39.21	Хуванцраар хийсэн бусад хавтан, хуудас, хальс, фольга болон тууз (зүйл 3921.13-т заасан полиуретаны торлог хуванцар, 3921.19-д заасан бусад хуванцар бүтээгдэхүүн хамаарна)
	39.22	Хуванцар ванн, босоо шүршүүрт ванн, угаагуур, тосгуур, биде, жорлон, жорлонгийн суултуур болон таг, жорлонгийн усны сав болон тэдгээртэй төстэй сантехникийн зориулалттай зүйлс
	39.23	Хуванцраар хийсэн, барааг зөөвөрлөхөд, эсвэл савлаж бооход зориулагдсан бүтээгдэхүүн; хуванцар бөглөө, таглаа болон бусад хаалт
	39.25	Барилгын зориулалттай, бусад газар заагдаагүй хуванцар зүйлс (зүйл 3925.10, 3925.30-аас бусад хамаарна)
АРЬС, ШИРЭН ТҮҮХИЙ ЭД, БОЛОВСРУУЛСАН АРЬС ШИР, ҮСЛЭГ АРЬС БОЛОН ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛ; СУРАН ЭДЛЭЛ БОЛОН ТОНОГ ХЭРЭГСЭЛ; АЯНЫ ХЭРЭГСЭЛ, ЭМЭГТЭЙ ХҮНИЙ ЦҮНХ БОЛОН ТҮҮНТЭЙ ТӨСТЭЙ УУТ САВ; МАЛ АМЬТНЫ ӨЛӨН ГЭДСЭЭР ХИЙСЭН ЗҮЙЛС (ТӨӨЛҮҮР ХОРХОЙН УТАСНААС БУСАД)		
41	41.04	Үхэр (одос үхэр орно), эсвэл адууны идээлсэн буюу идээлж-хатаасан, хавтгайгаар зүссэн (хуулдас), эсвэл зүсээгүй (бүтэн) (гэхдээ цаашдын боловсруулалт хийгээгүй) үсгүй шир
	41.05	Хонь, эсвэл хурганы идээлсэн буюу идээлж-хатаасан, хавтгайгаар зүссэн (хуулдас), эсвэл зүсээгүй (бүтэн) (гэхдээ цаашдын боловсруулалт хийгээгүй) үсгүй арьс
	41.06	Бусад мал, амьтдын идээлсэн, эсвэл идээлж-хатаасан, хавтгайгаар зүссэн (хуулдас) буюу зүсээгүй (бүтэн) (гэхдээ цаашдын боловсруулалт хийгээгүй) үс, ноосгүй арьс, шир



	41.07	Үхэр (одос үхэр орно), эсвэл адууны идээлэх буюу идээлж-хатаах боловсруулалт хийсний дараа цаашдын боловсруулалт хийсэн (элдэж зөөлрүүлсэн савхи орно), үсгүй, хавтгайгаар зүссэн (хуулдас), эсвэл зүсээгүй (бүтэн), зүйл 41.14-т зааснаас бусад савхи
	41.13	Бусад мал, амьтдын арьсыг идээлэх, эсвэл идээлж-хатаах боловсруулалт хийсний дараахь цаашдын боловсруулалт хийсэн (элдэж-зөөлрүүлсэн савхи орно), үс ноосгүй, хавтгайгаар зүссэн (хуулдас), эсвэл зүсээгүй (бүтэн), зүйл 41.14-т зааснаас бусад савхи
	41.14	Илгэн савхи (хиймэл илгэн савхи орно); лакадсан савхи болон лакадсан бүрмэл савхи; металлжуулсан савхи
42	42.03	Савхи, хиймэл савхиар хийсэн хувцас болон хувцасны тоног хэрэглэл
43	43.02	Зүйл 43.03-т зааснаас бусад, идээлсэн, эсвэл өнгө засал хийсэн үслэг арьс (толгой, сүүл, савар болон бусад хэсгүүд, огтолсон зүйлс), эгнэсэн (өөр төрлийн материал оруулаагүй), эсвэл эгнээгүй
	43.03	Үслэг эдлэлээр хийсэн, хувцасны зүйлс, хувцасны тоноглол болон бусад зүйлс
МОД БОЛОН МОДОН ЭДЛЭЛ; МОДНЫ НҮҮРС; ҮЙС БОЛОН ҮЙСЭН ЭДЛЭЛ; СҮРЛЭН, СИЙРСЭН, ЭСВЭЛ СҮЛЖИХ БУСАД МАТЕРИАЛААР ХИЙСЭН ЗҮЙЛС; САГСАН ЗҮЙЛС БА СҮЛЖЭЭСЭН БУСАД ЭДЛЭЛ		
44	44.08	Бүх төрлийн модон материал
	44.18	Барилгын модон хаалга, цонх, тагтны хаалга
		Сурагчийн ширээ, сандал
МОДНЫ, ЭСВЭЛ БУСАД ЦЕЛЛЮЛОЗОН ШИРХЭГТ МАТЕРИАЛЫН ЗУТАН; СЭРГЭЭН БОЛОВСРУУЛСАН (ХАЯГДАЛ БОЛОН ӨӨДӨС) ЦААС, ЭСВЭЛ КАРТОН; ЦААС БОЛОН КАРТОН, ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЗҮЙЛС		
48	48.02	Бичгийн, хэвлэлийн, эсвэл зураг зүйн болон перфокарт, перфолентний зориулалтын нүхлээгүй, гадна талдаа өнгөлгөөгүй, ямар ч хэмжээтэй байж болох хуйлмал, эсвэл тэгш өнцөгт (квадрат орно) хэлбэрийн хуудсан цаас (зүйл 48.01, 48.03-т заасан цааснаас бусад); гар үйлдвэрлэлийн цаас болон картон





	48.03	Гэр ахуй, ариун цэврийн зориулалттай гар нүүр, жорлонгийн цаас, цаасан алчуур, амны цаасан алчуур буюу тэдгээртэй төстэй цаас, гадаргууд нь хэв, атираа, нугалаас үүсгэсэн, нүхэлсэн, будсан, хээлж чимэглэсэн буюу ийм боловсруулалт хийгээгүй, хуудаслан зүссэн буюу хуйлмал хэлбэрийн, целлюлозон хөвөн ба целлюлозон зулмал
НЭХМЭЛИЙН МАТЕРИАЛ БОЛОН НЭХМЭЛ ЭДЛЭЛ		
51	51.05	Сэмлэсэн, эсвэл самнасан, хонины ноос буюу мал, амьтны нарийн, эсвэл бүдүүн үс, ноос, хялгас (самнасан тайрмал ноос орно)
	51.07	Жижиглэн худалдаалах зориулалтаар савлаагүй, хонины сэмлэсэн ноосон ээрмэл
	51.11	Хонины сэмлэсэн ноос, эсвэл бусад мал, амьтны сэмлэсэн нарийн үс, ноосоор нэхсэн даавуу
	51.12	Хонины самнасан ноос, эсвэл мал, амьтны самнасан нарийн үс, ноосоор нэхсэн даавуу
57	57.01	Зангидан нэхсэн хивс болон бусад нэхмэл дэвсгэр (гүйцэд боловсруулалт хийсэн, эсвэл хийгээгүй)
61	61.01	Эрэгтэйчүүдийн, эсвэл хөвгүүдийн пальто, богино хүрэм, нөмрөг, цув, юүдэнтэй хүрэм (түүнчлэн цанын хүрэм орно), салхи, борооны нимгэн хүрэм болон ижил төстэй сүлжмэл эдлэл (зүйл 61.03-т зааснаас бусад)
	61.02	Эмэгтэйчүүд, эсвэл охидын сүлжмэл пальто, богино хүрэм, нөмрөг, цув, юүдэнтэй хүрэм (түүнчлэн цанын хүрэм орно), салхи, борооны нимгэн хүрэм болон ижил төстэй сүлжмэл хувцас (зүйл 61.04-т зааснаас бусад)
	61.03	Эрэгтэйчүүдийн, эсвэл хөвгүүдийн, сүлжмэл костюм, хослол, пиджак, хүрэм, өмд, энгэрэвч болон мөрөвчтэй комбинзон, хагас урт өмд, богино өмд (усны хувцаснаас бусад)
	61.04	Эмэгтэйчүүд, охидын, сүлжмэл костюм, хослол, пиджак, хүрэм, даашинз, банзал, өмдөн банзал, урт өмд, энгэрэвч мөрөвчтэй комбинзон, хагас урт өмд, богино өмд (усны хувцаснаас бусад)
	61.05	Эрэгтэйчүүдийн, эсвэл хөвгүүдийн сүлжмэл цамц



	61.06	Эмэгтэйчүүдийн, эсвэл охидын сүлжмэл кофт, цамц, блузк	
	61.07	Эрэгтэйчүүдийн, эсвэл хөвгүүдийн сүлжмэл дотуур өмд, унтлагын цамц, унтлагын өмд цамцны хослол, усны, гэрийн халат болон ижил төстэй сүлжмэл зүйлс	
	61.08	Эмэгтэйчүүдийн, эсвэл охидын сүлжмэл сарафан, дотуур банзал, дотуур өмд, агтавч, унтлагын даашинз, унтлагын өмд цамцны хослол, нимгэн халат, гэрийн болон усны халат	
	61.09	Сүлжмэл футболка, майк болон бусад дотуур цамц	
	61.10	Сүлжмэл свитер, джемпер, пуловер, кардиган, жилет болон эдгээртэй төстэй сүлжмэл эдлэл	
	61.11	Хүүхдийн сүлжмэл хувцас болон хувцасны сүлжмэл тоног хэрэглэл	
	61.12	Биеийн тамирын, цанын, усны сүлжмэл хувцас	
	62	62.01	Эрэгтэйчүүдийн, эсвэл хөвгүүдийн оёмол пальто, богино хүрэм, нөмрөг, цув, юдэнтэй хүрэм (цанын хүрэм орно), салхи борооны цув, хүрэм болон зүйл 62.03-т зааснаас бусад тэдгээртэй төстэй хувцас
		62.02	Эмэгтэйчүүдийн, эсвэл охидын оёмол пальто, богино хүрэм, нөмрөг, цув, юдэнтэй хүрэм (цанын хүрэм орно), салхи, борооны цув, хүрэм болон зүйл 62.04-т зааснаас бусад гадуур хувцас
		62.03	Эрэгтэйчүүдийн, эсвэл хөвгүүдийн костюм, хослол, пиджак, хүрэм, урт өмд, энгэрэвчтэй болон мөрөвчтэй комбинзон, хагас урт өмд, богино өмд (усны хувцас орохгүй)
		62.04	Эмэгтэйчүүдийн, эсвэл охидын костюм, хослол, пиджак, хүрэм, даашинз, банзал, өмдөн банзал, урт өмд, энгэрэвчтэй болон мөрөвчтэй комбинзон, хагас урт өмд, богино өмд (усны хувцас орохгүй)
		62.05	Эрэгтэйчүүдийн, эсвэл хөвгүүдийн оёмол цамц
62.06		Эмэгтэйчүүдийн, эсвэл охидын блузк, цамц, кофт	
62.07		Эрэгтэйчүүдийн, эсвэл хөвгүүдийн майк, дотуур өмд, унтлагын цамц, унтлагын өмд цамцны хослол, усны, гэрийн халат болон ижил төстэй зүйлс	



	62.08	Эмэгтэйчүүдийн, эсвэл охидын майк, сарафан, дотуур банзал, дотуур өмд, унтлагын даашинз, унтлагын өмд цамцны хослол, гэрийн нимгэн халат, усны, гэрийн халат болон ижил төстэй зүйлс
	62.09	Хүүхдийн оёмол хувцас болон хувцасны оёмол тоног, хэрэглэл
	62.11	Биеийн тамирын, цанын, усны хувцас; бусад хувцас
	62.12	Оёмол, эсвэл сүлжмэл, хөхний даруулга, бүс, гэдэсний даруулга, мөрөвч, өмдний татуурга, оймсны татуурга болон тэдгээртэй ижил төстэй эдлэл болон тэдгээрийн эд анги
63	63.02	Орны цагаан хэрэглэл, ширээний, ариун цэврийн өрөөний болон гал тогооны давуун хэрэглэл
ЧУЛУУ, ГИПС, ЦЕМЕНТ, ШӨРМӨСӨН ЧУЛУУ, ГЯЛТГАНУУР, ЭСВЭЛ ТЭДГЭЭРТЭЙ ТӨСТЭЙ МАТЕРИАЛААР ХИЙСЭН ЗҮЙЛС; КЕРАМИК ЭДЛЭЛ; ШИЛ БОЛОН ШИЛЭН ЭДЛЭЛ		
68	68.01	Байгалийн чулуу (занараас бусад)-гаар хийсэн дөрвөлжин чулуу, замын хашлага, дэвсгэр хавтанцар
	68.06	Шаарган хөвөн, эсвэл тэдгээртэй төстэй эрдэс хөвөн; үелсэн вермикулит, хөөдөг шавар, хөөсөнцөр шаараг болон бусад хөөдөг эрдэс материал; зүйл 68.11, 68.12, эсвэл 69-р бүлэгт зааснаас бусад дулаан тусгаарлах, дуу тусгаарлах, дуу шингээх холимог материалаар хийсэн бүтээгдэхүүн
	68.07	Асфальт, эсвэл түүнтэй төстэй материал (жишээлбэл: нефтийн битум, чулуун нүүрсний давирхай)-аар хийсэн бүтээгдэхүүн
	68.08	Цемент, гипс, бусад эрдэс материалан холбогчтой ургамлын мяндас, сүрэл, модны үртэс, зоргодос, зах, эсвэл модны бусад хаягдлаар хийсэн хавтан, хавтанцар, гулдмай болон адил төст зүйлс
	68.09	Барилгын дотор хана-ханын гипсэн гулдмай
	68.10	Цемент, бетон болон хиймэл чулуун, хүчитгэсэн, эсвэл хүчитгээгүй бүтээгдэхүүн
		Барилгын дотор хана-угсармал хавтан
Бетон дэр		
		Бетон зуурмаг түргэн бэхжүүлэгч



	68.11	Магнийн барьцалдуулагчтай, шилэн мяндсан арматурт хавтан
		Магнийн барьцалдуулагчтай, шилэн мяндсан арматурт дээврийн долгионт хавтан ба хоолой
		Шилэн мяндсан арматуртай, агааржуулалтын магnezитан хоолой
		Шилэн мяндсан арматуртай, цементэн салхивчны сувгийн хоолой
69	69.02	Цахиурлаг шороон хүдэр (жишээ нь: силикагель, триполит, диатомит), эсвэл түүнтэй төстэй цахиурлаг шавраар хийсэн тоосго, блок, хавтан болон керамик бусад эдлэл (царууц тоосго)
		Барилгын керамик тоосго, шалны блок, тулгуурын болон өнгөлгөөний хавтан болон эдгээртэй төстэй керамик эдлэл
	69.07	Барилгын шалны өнгөлгөөний керамик хавтанцар
		Барилгын ханын гадаа өнгөлгөөний керамик хавтанцар
		Барилгын ханын дотор өнгөлгөөний керамик хавтанцар
70	70.07	Барилгын шил-аюулгүйн бэхжүүлсэн (уяраасан) шил
		Барилгын шил-аюулгүйн үелүүлсэн шил
	70.08	Олон давхар ханатай тусгаарлагч шил
<b>ҮНДСЭН МЕТАЛЛ БОЛОН ҮНДСЭН МЕТАЛЛААР ХИЙСЭН ЗҮЙЛС</b>		
72	72.06	Цутгамал, эсвэл анхдагч бусад хэлбэртэй төмөр болон чанаржуулаагүй ган (зүйл 72.03-т заасан төмрөөс бусад)
	72.13	Халуунаар цувисан, зөв бус хэлбэрийн ороомог байдалтай, төмөр, эсвэл чанаржуулаагүй гангаар хийсэн цулдан болон туйван
	72.14	Давтах, халуунаар цувих, халуунаар сунгах болон даралтаар шахах, цувихаас цаашид боловсруулалт хийгээгүй, цувисны дараа мушгисан, төмөр, эсвэл чанаржуулаагүй гангаар хийсэн бусад цулдан болон туйван
	72.15	Төмөр, эсвэл чанаржуулаагүй гангаар хийсэн бусад цулдан болон туйван
	72.16	Төмөр, эсвэл чанаржуулаагүй гангаар хийсэн булан, хэлбэрт болон сортын төмөр



73	73.02	Төмөр зам, эсвэл трамвайн замын зориулалттай төмөр, эсвэл гангаар хийсэн дараахь зүйлс: зам төмөр, чиглүүлэгч, араат зам төмөр, зам шилжүүлэгч, зөрлөгийн чагтан холбоос, зам шилжүүлэгчийн татуурга болон бусад чагтан холбоос эд анги, зам төмрийн суурийн даруулга, зам төмрийн залгаасны даруулга, зам төмрийн дэр, дэрний бэхэлгээний гадас, суурийн хавтан, хавчигч суурь, зам төмрийн холбоос, дэр болон зам төмрийг холбох бэхлэх зориулалттай бусад зүйлс. (зүйл 7302.10-г заасан зам төмөр хамаарна)
	73.03	Ширмэн, нарийн, бүдүүн хоолой ба хөндий огтолбор
	73.04	Төмөр (ширэмнээс бусад), эсвэл гангаар хийсэн, ширээсгүй, нарийн бүдүүн хоолой болон хөндий огтолбор
	73.08	Төмөр хийц, түүний эд анги, төмөр буюу гангаар хийсэн төмөр хийц үйлдвэрлэх зориулалттай хавтан, туйван, булан хэлбэрт болон сортын төмөр хоолой ба тэдгээртэй төстэй зүйлс
	73.12	Цахилгаан тусгаарлагчгүй, төмөр, эсвэл ган томсон утас, олс, кабель, сүлжсэн тууз, татлага болон эдгээртэй төстэй зүйлс
	73.25	Төмөр, эсвэл гангаар хийсэн бусад цутгамал эдлэл
	73.26	Төмөр, эсвэл гангаар хийсэн бусад эдлэл
74	74.03	Тунгаасан зэс болон боловсруулалт хийгээгүй зэсийн хайлш (зүйл 7403.21-д заасан зэс-цайрын хайлш (гууль))
	74.08	Зэс утас
76	76.05	Хөнгөн цагаан утас
	76.10	Хөнгөн цагаан хайлшин цонх
		Даралтад ажиллах ган хоолой (гадна дулаан, халаалт, цэвэр усны)
		Даралтад ажиллах ширмэн хоолой (гадна дулаан, халаалт, цэвэр усны)



83	83.11	Үндсэн металл, эсвэл карбид металлаар хийсэн, флюсээр бүрхэвчтэй, буюу флюсэн голтой, металл, эсвэл карбид металлыг хүйтнээр, халуунаар гагнах, ширэх буюу металл буюу карбид металлан бүрхүүл суулгах зориулалттай утас, саваа, хоолой, хавтан электрод болон эдгээртэй төстэй зүйлс; металлээр шүршихэд зориулсан, үндсэн металлын бөөмнөрүүлсэн нунтагаар хийсэн утас, саваа (зүйл 8311.10-т заасан цахилгаан нуман гагнуурын зориулалттай, бүрхэвчтэй, үндсэн металлаар хийсэн электрод хамаарна)
МАШИН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН МЕХАНИК ТӨХӨӨРӨМЖ; ЦАХИЛГААН ХЭРЭГСЭЛ; ТЭДГЭЭРИЙН ЭД АНГИ; ДУУ БИЧИХ, СЭРГЭЭХ ТӨХӨӨРӨМЖ, ТЕЛЕВИЗИЙН ДҮРС, ДУУ БИЧИХ БОЛОН СЭРГЭЭХ ТӨХӨӨРӨМЖ, ТЭДГЭЭРИЙН ЭД АНГИ, ТОНОГ ХЭРЭГСЭЛ		
84	84.16	Шингэн түлш, нунтагласан хатуу түлш, эсвэл хийн түлш шатаах зуухны хотол; механик галлагч (механик сараалж, үнс зайлуулагч болон бусад адил төстэй төхөөрөмж орно)
	84.18	Хөргөгч, хөлдөөгч, цахилгаан, эсвэл бусад төрлийн хөргөх, хөлдөөх төхөөрөмж; зүйл 84.15-д заасан агаар тохируулагч төхөөрөмжөөс бусад дулааны насос
	84.22	Сав суулга угаах машин; лонх, эсвэл бусад сав суулга цэвэрлэх, хатаах төхөөрөмж; лонх, лааз, хайрцаг, уут, эсвэл бусад саванд савлах, таглах, битүүмжлэх буюу шошголох машин; лонх, шилэн сав, бортого, эсвэл эдгээртэй төстэй савыг мембран таглаагаар таглах, бөглөө, эсвэл таглааг бүрэх машин; баглаа боодлын бусад машин (халааж наалдуулан боох машин орно); ундаа хийжүүлэх машин (зүйл 8422.11-д заасан гэр ахуйн зориулалттай нь орно)
	84.28	Ачааг өргөх, зөөх, ачих, буулгах зориулалтын бусад техник хэрэгсэл (жишээ нь: лифт, хөвөрдөг шат, конвейер, татлагат зам)
85	85.08	Тоос сорогч
	85.09	Зүйл 85.08-ын тоос сорогчоос бусад, гэр ахуйн зориулалттай, өөртөө цахилгаан мотор бүхий цахилгаан-механик хэрэгсэл
	85.10	Өөртөө цахилгаан мотор бүхий сахлын машин, үс засах, үс хяргах хэрэгсэл



85.16	Усхурдан буцалгагч, эсвэл халууныг хадгалдаг ус буцалгагч, дүрдэг халаагч; орчны агаарыг халаах цахилгаан аппарат болон газрын хөрс халаах аппарат; үсчний цахилгаан халаагуурт аппарат (жишээ нь: үс хатаагч, үс ороогч, үс буржийлгах хавчаарын халаагч) болон гар хатаагч; цахилгаан индүү; гэр ахуйн зориулалтын цахилгаан халаагуурт бусад хэрэгсэл; зүйл 85.45-д зааснаас бусад цахилгаан халаалтын эсэргүүцэл
85.17	Телефон аппарат (үүрэн сүлжээ, эсвэл утасгүй бусад сүлжээний зориулалтын телефон орно); зүйл 84.43, 85.25, 85.27 буюу 85.28-ын дамжуулах, эсвэл хүлээн авах аппаратаас бусад, дуу, дүрс буюу бусад мэдээллийг дамжуулах, эсвэл хүлээн авах төхөөрөмж (утсан буюу утасгүй сүлжээ (жишээ нь: дотоод сүлжээ /LAN/, гадаад сүлжээ /WAN/- ний төхөөрөмж орно)) (зүйл 8517.62.10, 8517.62.20-д зааснаас бусад орно)
85.25	Радиогийн өргөн нэвтрүүлэг, телевизийн нэвтрүүлэг дамжуулах аппарат (корпуст нь хүлээн авах, дуу бичих, сэргээх аппарат угсрагдсан, эсвэл угсрагдаагүй); телевизийн камер, дижитал камер болон видео бичлэгийн камер
85.26	Радиолокатор (радар)-ын аппарат, радионавигацийн тусламжийн аппарат болон радиогийн алсын удирдлагын аппарат
85.27	Радиогийн өргөн нэвтрүүлэг хүлээн авах аппарат (корпуст нь дуу бичих, сэргээх аппарат, эсхүл цаг угсрагдсан, эсвэл угсрагдаагүй) (зүйл 85.27-д заасан гадны эх үүсвэрээс тэжээл авахгүйгээр ажиллах боломжгүй, тээврийн хэрэгслийн зориулалттай радиогийн өргөн нэвтрүүлэг хүлээн авагч орно)
85.28	Телевизийн нэвтрүүлэг хүлээн авах аппаратгүй монитор болон проектор; телевизийн нэвтрүүлэг хүлээн авах аппарат (корпуст нь радиогийн нэвтрүүлэг хүлээн авах, дуу, видео бичлэг хийх, сэргээх аппарат угсрагдсан, эсвэл угсрагдаагүй)
85.44	Тонг төхөөрөмж, угсралтын ПВХ бүрхүүлтэй, 1000В хүртэл хүчдэлд ажиллах, тусгаарлагчтай зэс утас, түүнтэй төстэй эдлэл

87	87.08	Зүйл 87.01-87.05-д хамаарах моторт тээврийн хэрэгслийн эд анги, тоног хэрэгсэл (зүйл 8708.30-д заасан тоормос болон серво-тоормос; эдгээрийн эд анги, 8708.40-д заасан хурдны хайрцаг болон түүний эд анги, 8708.80-д заасан цохилт-зөөллөгч систем болон түүний эд анги хамаарна (амортизатор орно))
		Залгах механизм, түүний эд анги
		Жолооны хүрд, жолооны гол, жолооны механизм, эдгээрийн эд анги
		Автотээврийн хэрэгсэл үйлдвэрлэл, чиргүүл, хагас чиргүүл үйлдвэрлэл
90	90.18	Хүн эмнэлэг, мэс засал, шүдний эмнэлэг, эсвэл мал эмнэлгийн зориулалттай багаж, төхөөрөмж (сцинтиграфын аппарат орно), эмнэлгийн цахилгаан бусад аппарат, хараа шалгах багаж
	90.22	Хүн эмнэлэг, мэс засал, шүдний эмнэлэг, эсвэл мал эмнэлгийн зориулалттай, эсвэл зориулалтгүй, рентген туяаны, эсвэл альфа, бета, гамма цацрагийн аппарат (рентген зураг авах, цацраг эмчилгээний аппарат орно), рентген хоолой, рентген туяаны бусад үүсгүүр, хянах самбар, эсвэл ширээ, дэлгэц, үзлэг эмчилгээний ширээ, сандал болон эдгээртэй төстэй зүйлс
	90.27	Физикийн, эсвэл химийн шинжилгээний багаж, аппарат (жишээ нь: поляриметр, рефрактометр, спектрометр, хий, эсвэл утаа шинжлэх аппарат); зууралдамтгай чанар, сүвширэл, тэлэлт, гадаргын таталцлын хэмжих, хянах багаж, аппарат, эсвэл эдгээртэй төстэй багаж, аппарат; дулаан, авиа, эсвэл гэрлийн тоо хэмжээг хэмжих, хянах багаж, аппарат (экспонометр орно); микротом (бичил зүслэгийн багаж)
	90.28	Хий, шингэн бүтээгдэхүүн болон цахилгаан эрчим хүчний нийлүүлэлт, тооцоонд ашиглах хэмжих хэрэгсэл
		Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд ашиглах хэмжих хэрэгсэл
		Байгалийн нөөц, баялагийн ашиглалт, худалдаа үйлчилгээний тооцоонд хэрэглэх хэмжих хэрэгсэл
<b>АЖ ҮЙЛДВЭРИЙН ТӨРӨЛ БҮРИЙН БАРАА</b>		
95	95.03	Унадаг гурван дугуйт, скүүтэр, гишгүүрт машин болон эдгээртэй төстэй дугуйт тоглоом; хүүхэлдэйн тэрэг; хүүхэлдэй; бусад тоглоом; хэмжээ (масштаб)-г нь багасгасан загвар болон түүнтэй төстэй, зугаа цэнгээний хөдөлгөөнт, эсвэл хөдөлгөөнт биш загвар; бүх төрлийн эвлүүлдэг оньсон тоглоом (puzzle)





**Б. БАТАЛГААЖУУЛАЛТАД ХАМРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ**

1	Үсчин
2	Гоёлын гоо засал
3	Халуун ус
4	Саун
5	Хими цэвэрлэгээ
6	Нийтийн тээвэр
7	Зочид буудал
8	Жуулчны бааз, амралтын газар
9	Нийтийн хоолны газар
10	Хүнсний дэлгүүр, хүнсний бүтээгдэхүүний бөөний худалдаа
11	Хүүхдийн зуслан
12	Бассейн
13	Чийрэгжүүлэлтийн төв
14	Алжаал тайлах иллэг
15	Хүүхдийн тоглоомын газар
16	Шуудан

**В. ТЕХНИКИЙН ХЯНАЛТАД ХАМРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ**

1	Автомашинь оношилгоо болон засвар
2	Шатахуун түгээх станц
3	Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг
4	Аж үйлдвэрийн бүх салбар (төмөр зам, нисэх, эрчим хүч, барилга, уул уурхайн) үл эвдэх сорилт
5	Өргөн тээвэрлэх төхөөрөмж
6	Даралтат сав, түүний ашиглалт
7	Ачаа тээвэрлэх, ачиж буулгах төхөөрөмж
8	Аюултай ачаа тээвэрлэлт
9	Төмөр замын засвар
10	Төмөр замын техникийн оношлогоо
11	Төмөр замын техникийн үзлэг, үйлчилгээ

Засгийн газрын 2018 оны 291 дүгээр  
тогтоолын 2 дугаар хавсралт

ТОХИРЛЫН БАТАЛГААТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГ  
МОНГОЛ УЛСЫН ЗАХ ЗЭЭЛД НИЙЛҮҮЛЭХ, УЛСЫН  
ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн хүрээнд бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэн тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээ (цаашид “бүтээгдэхүүн” гэх)-г Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.3. Энэхүү журамд хэрэглэсэн тохирлын баталгаатай холбогдолтой нэр томъёог Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Олон улсын стандартчиллын байгууллага (ISO), Олон улсын цахилгаан техникийн комисс (IEC)-ын арга зүйн удирдамжид заасан утгаар ойлгоно.

1.4. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт” (цаашид “жагсаалт” гэх)-д заасан бүтээгдэхүүнийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн тохирлын баталгаанд заавал хамруулна.

1.5. Бүтээгдэхүүний тохирлын үнэлгээнд техникийн зохицуулалт, стандарт болон холбогдох бусад техникийн баримт бичгийг баримтална.

1.6. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд энэхүү журам хамаарахгүй.

1.7. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу Монгол Улсаас олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрээр стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээн зөвшөөрсөн тохирлын болон түүнтэй



адилтгах тэмдэг, гэрчилгээтэй, мөн хүчин төгөлдөр аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэхэд тохирлын үнэлгээнд давтан хамруулахгүй.

1.8. Жагсаалтад зааснаас бусад бүтээгдэхүүнийг заавал тохирлын баталгаатайгаар зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэхээр хууль, тогтоомж, худалдааны болон бусад гэрээ, хэлэлцээрт тусгасан, эсхүл хүлээн авагч талаас шаардсан бол энэ журмыг баримталж болно.

#### Хоёр. Тохирлын баталгаа

2.1. Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Монгол Улсад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах нийтлэг журам”-ын дагуу бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулна.

2.2. Баталгаажуулалтын байгууллага хүсэлт гаргагчаас ирүүлсэн өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

2.3. Жагсаалтад заасан бүтээгдэхүүнд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 23.1.2-т заасан, ISO IEC 17065 стандартын дагуу итгэмжлэгдсэн, томилогдсон байгууллагаас тохирлын гэрчилгээ, аюулгүйн тэмдэг олгоно.

2.4. Жагсаалтад заасан согтууруулах ундаа, тамхины төрлийн импортын бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхийн өмнө тухайн бүтээгдэхүүний загварыг тохирлын үнэлгээнд заавал хамруулна.

2.5. Аюулгүйн тэмдгийг Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Аюулгүйн тэмдгийн хэлбэр, хэмжээ, хэрэглэх журам”-ын дагуу олгоно.

2.6. Жагсаалтад тусгагдаагүй бүтээгдэхүүнийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь сайн дурын үндсэн дээр тохирлын үнэлгээнд хамруулж, баталгаажуулалтын байгууллага тохирлын гэрчилгээ олгож болно.

2.7. Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Нийлүүлэгчийн мэдэгдлийг гаргах, бүртгэх журам”-ын дагуу гаргасан нийлүүлэгчийн мэдэгдэл нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 14.6-д заасны дагуу тохирлын гэрчилгээний нэгэн адил хүчин төгөлдөр байна.

2.8. Тохирлын үнэлгээг Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас эрх авсан баталгаажуулалтын мэргэшсэн шинжээч хийнэ.

2.9. Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталгаажуулалтын шинжээчийн дүрмийг батална.

Гурав. Бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх,  
хилээр нэвтрүүлэх

3.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь жагсаалтад заасан бүтээгдэхүүнийг тохирлын баталгаанд хамруулсны дараа зах зээлд нийлүүлэх буюу улсын хилээр нэвтрүүлнэ.

3.2. Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас энэхүү журмын 1.7-д хамаарах дараахь мэдээллийг гаалийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон мэргэжлийн хяналтын төв байгууллагад тухай бүр өгч байна:

3.2.1. Засгийн газраас баталсан “Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт”-ын баталгаат хувь;

3.2.2. Итгэмжлэгдсэн, томилогдсон баталгаажуулалтын байгууллагын жагсаалт, танилцуулга;

3.2.3. Итгэмжлэгдсэн, томилогдсон баталгаажуулалтын байгууллагаас олгох аюулгүйн тэмдэг, тохирлын гэрчилгээ, нийлүүлэгчийн мэдэгдлийн баталгаат загвар;

3.2.4. Олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн хуулбарын баталгаат хувь;

3.2.5. Олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрээр хүлээн зөвшөөрсөн тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг, гэрчилгээний баталгаат загвар.

3.3. Жагсаалтад заасан бүтээгдэхүүнийг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэхэд гаалийн болон мэргэжлийн хяналтын байгууллага дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



3.3.1. энэхүү журамд заасан шаардлага хангасан, баримт бичгийн зөрчилгүй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрөх;

3.3.2. бүтээгдэхүүнийг экспортлогч орны эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаас олгосон хүчин төгөлдөр тохирлын гэрчилгээ, нийлүүлэгчийн мэдэгдэлгүйгээр улсын хилээр нэвтрүүлэхгүй байх.

3.4. Жагсаалтад зааснаас бусад бүтээгдэхүүнийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зах зээлд нийлүүлэх буюу улсын хилээр нэвтрүүлнэ.

3.5. Энэхүү журмын 1.7-д хамаарах бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт, сорилт шинжилгээ давтан хийхээс чөлөөлнө.

#### Дөрөв. Бусад

4.1. Бүтээгдэхүүний тохирлын баталгаатай холбоотой зөрчилд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2019 оны 1 дүгээр  
сарын 16-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

**Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн  
60.5 дахь хэсгийн зохицуулалтаар Цэцийн 2010 оны  
01 дүгээр тогтоолоор хүчингүй болсон хуулийн  
заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх  
маргааныг эцэслэн хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн  
хуралдааны танхим 14.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат, Д.Ганзориг, Ш.Цогтоо, Д.Солонго /илтгэгч/, Б.Буяндэлгэр, Г.Туулхүү, Ш.Солонго нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Б.Амартүвшин, Я.Баярсайхан болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй.” гэж зааснаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон 2005 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх тухай маргааныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн хяналтын журмаар хянан шийдвэрлэв.

***Нэг. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны оршин суугч, иргэн Б.Амартүвшин Үндсэн хуулийн цэцэд хандаж ирүүлсэн мэдээлэлдээ:***

“Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтад “... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. ...”, мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэсэн хэм хэмжээг тус тус зөрчсөн гэж үзэж байна.

Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2005 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтыг хүчингүй болгосон боловч Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуульд дахин оруулж ирсэн нь нам, эвсэл, иргэнийг зардлын тайлангаа гаргаж өгөөгүй, эсвэл хуульд заасан хугацаанаас хоцроосон алдаатай үйлдлийнхээ төлөө Сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.7 дахь хэсэгт заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод



хэмжээг 21-26 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл хүлээж байгаа боловч нэг удаагийн алдаатай үйлдлийнхээ төлөө дахин сонгуульд оролцох эрхээ хасуулж байгаа нь хууль зүйн шинжлэх ухааны нэг алдаанд нэг шийтгэл ногдуулах зарчмыг алдагдуулж байна.

Аль нэг нам, эвсэл хариуцлагагүй ажилтны гаргасан алдаа, эсхүл санаатайгаар өрсөлдөгчөө намнах хуйвалдаанаас болж гаргасан зөрчлийн улмаас бусад гишүүд, дэмжигчдийн сонгогдох эрхийг хязгаарлаж байгаа нь Үндсэн хуульд харшилж байна гэж үзэж байгаа тул Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хяналтын журмаар шийдвэрлэж, уг заалтыг хүчингүй болгож өгнө үү.” гэсэн байна.

***Хоёр. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч, иргэн Я.Баярсайхан Үндсэн хуулийн цэцэд хандаж:***

“Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хүчингүй болсон 2005 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтыг агуулгын хувьд шууд сэргээн хэрэглэсэн гэж үзэж байна.

Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр тогтоолын тогтоох хэсэгт “2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтын “... Аль нэгэн нам, ... гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. ...” гэснийг тус тус зөрчсөн байх тул Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол” гэснийг хүчингүй болгосугай. ...” гэж дурдсан.

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй.” гэсэн заалт нь Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болсон Монгол Улсын Их Хурлаас 2005 онд баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Дараахь тохиолдолд нам, эвслийг бүртгэхээс татгалзана.” гээд 26.3.6

дахь заалтад “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол.” гэсэн заалтыг шууд агуулгаар нь дахин сэргээн хэрэглэсэн байна. Энэ нь Монгол Улсын иргэний болон намын гишүүд, дэмжигчдийн ардчиллын үнэт зүйлс болсон сонгох, сонгогдох эрхийг хязгаарласан үйлдэл юм.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааны шийдвэрээр хүчингүй болсон, Монгол Улсын иргэний эрхэд халдсан, Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсгийг хүчингүй болгож өгнө үү.” гэсэн агуулгатай мэдээлэл ирүүлсэн байна.

***Гурав. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:***

“... Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтын “... Аль нэгэн нам, ... гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. ...” гэснийг тус тус зөрчсөн байх тул Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол” гэснийг хүчингүй болгосугай.” хэмээн шийдвэрлэсэн нь зөвхөн тухайн үед үйлчилж байсан хуульд хамаарч байгаа бөгөөд 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай уг хуулийг 2011 оны 12 дугаар зүйлийн 15-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.

Хүчингүй болсон дээрх хуульд “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол” гэж заасан 26 дугаар зүйлийн гарчиг нь “Сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх” гэж байсан бөгөөд үүгээр зөвхөн нам, эвслийг бүртгэхтэй холбоотой явцуу харилцааг зохицуулж байсан юм. Үндсэн хуулийн цэцийн энэ талаар гаргасан дээрх шийдвэр ч зөвхөн бүртгэх үйл ажиллагаанд хамаарах агуулгатай гарсан гэж ойлгогдохоор байна.





Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар зүйлийн 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн гарчиг нь “Сонгуулийн зардлын тайлангийн хяналт ба нээлттэй, ил тод байдал” гэж байгаа бөгөөд тус зүйлийн 60.5 дахь хэсэгт “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй.” гэсэн заалтад бүртгэхгүй байх үндэслэлийг: нэгдүгээрт, сонгуулийн зардлаа тайлагнах тухай хуулийн заалтыг биелүүлээгүйгээр хууль зөрчсөн эс үйлдэл, хоёрдугаарт, сонгуулийн ажиллагаа хууль ёсоор, шударга явагдаж байгаа эсэхэд иргэд, сонирхогч талууд бүрэн хяналт тавих, энэ талаар үнэн бодитой мэдээлэл авах бололцоог алдагдуулсан хууль бус үйлдэлд хамааруулсан ба бүртгэхгүй байж болох субъектэд нэр дэвшигч иргэн нэмэгдэж тусгагдсан. Хууль тогтоогчийн зүгээс энэ хуульд зөвхөн бүртгэхгүй байх үйлдлийг биш түүний үндэслэлийг гол болгож авч үзэж тусгасан болохыг онцлон тэмдэглэж байна. Үүгээрээ 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтаас агуулгын хувьд ялгаатай.

Хууль зөрчсөн үйлдэл, эс үйлдлийнхээ эрх зүйн үр дагаврыг нэр дэвшигч иргэн, нам, эвсэл хэн боловч гарцаагүй хариуцаж байх нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэсэн заалтын шударга ёс, тэгш байдал, хууль дээдлэх зарчмын агуулгад бүрэн дүүрэн нийцнэ гэж үзэж байна. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн эсэх тухай асуудлыг авч үзэхдээ Үндсэн хуулийн үндсэн зарчим алдагдахгүй байх нөхцөлийг заавал тооцож үзэх ёстой гэдгийг Улсын Их Хурал хууль тогтоох үзэл баримтлалдаа удирдлага болгодог. Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй.” гэсэн заалтаар хуулиар хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлсэн иргэн, нам, эвслийг улс төрийн сонгуульд оролцох эрх ашиг, эрх чөлөөг ямар ч байдлаар хязгаарлаагүй. Хуульд заасан үүргээ биелүүлээгүй зөрчсөн этгээд, хуулийг ёсчлон биелүүлдэг этгээд адил тэгш байдалтай сонгуульд оролцох нь сонгуулийн бодит байдалд сөрөг нөлөө үзүүлэх үр дагавар үүсгэх өндөр магадлалтайгаас гадна шударга ёс, хууль дээдлэх ёсны үндсэн зарчмыг зөрчиж байгаа Үндсэн хуулийн хамгийн ноцтой хэлбэр гэдгийг анхааран үзэхийг зориуд хүсэлт болгож байна.

Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсгийн заалт нь зөвхөн нэр дэвшигчийн бүртгэлээс өргөн агуулгатай бөгөөд тус

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад заасан хууль дээдлэх, 5.1.2 дахь заалтад заасан ил тод байдлыг хангах, 5.1.3 дахь заалтад заасан шударга ёсыг сахих зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тухайн хуульд тусгагдан хэрэгжиж байгаа тул үүгээр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол” гэж заасан байсныг агуулгаар нь дахин сэргээгээгүй бөгөөд Монгол Улсын Их Хурал энэ хуулийг тогтоохдоо түүнээс зарчмын ялгаатай үзэл баримтлалыг эш үндэс болгосон болно.” гэжээ.

***Дөрөв. Сонгуулийн ерөнхий хорооны даргын “Мэдээлэл хүргүүлэх тухай” 2018 оны 70 дугаар албан бичигт:***

“Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцохоор Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн 12 нам, 3 эвсэл, 498 нэр дэвшигчдээс 1 нам (Иргэний зориг ногоон нам), 1 эвсэл, 104 нэр дэвшигч нь хуульд заасан хугацаанд зардлын тайлангаа ирүүлээгүй болно.

Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй.” гэж заасан бөгөөд зардлын тайлангаа ирүүлээгүй дээр дурдсан нам, эвсэл, нэр дэвшигчтэй холбоотой өргөдөл, гомдол тус хороонд ирээгүй бөгөөд шүүхэд хандаж шийдвэрлүүлсэн мэдээлэл байхгүй байна.” гээд сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй нам, эвсэл, нэр дэвшигчдийн судалгааг хавсралтаар ирүүлсэн байна.

**ҮНДЭСЛЭЛ:**

1. Монгол Улсын Их Хурал сонгуулийн тухай хуулийг шинэчлэн 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталжээ. Ийнхүү батлахдаа сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийг бүртгэх, бүртгэхээс татгалзах талаарх зохицуулалтад өөрчлөлт оруулсан байна. Харин сонгуулийн сурталчилгааны эдийн засгийн үндсийг зохицуулсан хэм хэмжээг тусгай бүлэг болгон хуульчилж, “Сонгуулийн зардлын хяналт” гэсэн дэд бүлэгт холбогдох зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх Үндсэн хуулийн эрх зүйн болон захиргааны эрх зүйн хариуцлагын төрлийг тусгасан байна.

Энэ хүрээнд Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд



бүртгэхгүй.” гэж сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд ирүүлээгүй нам, эвсэл, нэр дэвшигчид хүлээлгэх хариуцлагыг хуульчилжээ.

2. Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсгийн зорилго, мөн чанар, эрх зүйн үр дагавар нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон хуулийн зохицуулалтаас өөр байна.

Тодруулбал, Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон 2005 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн “Нам, эвсэл сонгуульд оролцох” хэмээх Тавдугаар бүлгийн “Сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх” гэсэн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол” нам, эвслийг сонгуульд бүртгэхээс татгалзахаар хуульчилсан байсан нь хэм хэмжээний зорилгын хувьд зөвхөн нам, эвслийг сонгуульд бүртгэхтэй холбоотой харилцааг зохицуулж байсан ба сонгуульд оролцсон нам, эвсэл сонгуулийн зардлын тайлангаа Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол дараа дараагийн хэдэн ч удаагийн сонгуульд оролцуулахгүй байж болох тодорхой бус үргэлжилсэн үр дагаврыг үүсгэж тухайн намын гишүүд, дэмжигчдийнх нь сонгох, сонгогдох эрх хугацаагүйгээр хязгаарлагдахаар байжээ.

Харин 2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хуулийн “Сонгуулийн зардлын хяналт” хэмээх Зургадугаар дэд бүлгийн “Сонгуулийн зардлын тайлангийн хяналт ба нээлттэй, ил тод байдал” гэсэн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй.” гэж заасан нь зорилгын хувьд сонгуулийн хуулийн хэрэгжилтийг хангах, сонгуулийн сурталчилгаа төдийгүй сонгуулийн үйл ажиллагаа хууль ёсоор, шударга явагдаж байгаа эсэхэд хяналт тавих, энэ талаар бодит мэдээллийг гаргуулахын тулд хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй байж дараагийн сонгуульд оролцуулахгүй байх хууль зүйн тодорхой хариуцлага тогтоожээ. Өөрөөр хэлбэл, уг зохицуулалтаар сонгуулийн зардлын хяналт, нээлттэй, ил тод байдлын үндсийг тогтоон сонгуулийн санхүүжилтийн болон зардлын тайлан гаргахыг шаардаж Үндсэн хуулийн эрх зүйн субъект болох улс төрийн намын санхүүгийн үйл ажиллагааг хөндлөнгийн хяналттай, хариуцлагатай болгож, сонгуулийн тэгш, шударга байдлыг баталгаажуулах, иргэний улс төрийн эрхийг хангах хууль зүйн баталгааг бүрдүүлсэн гэж үзэхээр байна.

Үүнээс үзэхэд 2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хуулийн дээрх зохицуулалт Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтын зохицуулалтаас агуулгын хувьд ялгаатай байна.

Иймд дээр дурдсан үндэслэл, үндсэн хуулийн эрх зүйн болон сонгуулийн эрх зүйн суурь онол, зарчим, нийтлэг хандлага, Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 04 дүгээр дүгнэлт, 2010 оны 01 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн маргааны архивын баримт, энэхүү маргааныг Их суудлын хуралдаанд бэлтгэх явцад цугларсан баримт, маргагч талуудын тайлбараас үзэхэд Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсгийн зохицуулалтаар Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон холбогдох хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж заасан бөгөөд уг зохицуулалтаар ард түмнээс засгийн эрхээ хэрэгжүүлэхдээ төрийн үйл хэрэгт шууд буюу сонгож байгуулсан төлөөллийн байгууллагаар уламжлан оролцох үзэл баримтлалын үндсийг тогтоожээ.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтад “... Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. ...”, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад Монгол Улсын иргэн “Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;” үндсэн үүрэгтэй болохыг хуульчилсан байдаг.

Үүнээс үзэхэд хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй байх агуулга бүхий хууль зүйн хариуцлага тогтоосон нь дээр дурдсан үзэл баримтлал, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах болон тухайн намын дотоод хяналтыг сайжруулах, намын гишүүдийг хариуцлагажуулах, хууль дээдлэх зарчмыг хангах, Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно.” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн зохицуулалт хэмээн үзэх үндэслэлтэй байна.



Харин Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааны явцад гаргасан маргагч талуудын тайлбар, хуралдаанд бэлтгэх ажиллагааны явцад цугларсан бусад баримт судалгааг үзэхэд улс төрийн сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн санхүүжилт, зардлын тайлангаа хуульд заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хоцроох зэрэгтэй холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байгааг тэмдэглэх нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, Жаран зургадугаар зүйлийн 1, 4, Жаран долдугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3, 31 дүгээр зүйлийн 1, 32 дугаар зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг удирдлага болгон

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:**

1. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй.” гэсэн зохицуулалтаар Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон 2005 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтыг агуулгаар нь дахин сэргээн батлаагүй байна гэж үзсүгэй.

2. Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагц хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Д.ОДБАЯР**

**ГИШҮҮД**

**Н.ЧИНБАТ  
Д.ГАНЗОРИГ  
Ш.ЦОГТОО  
Д.СОЛОНГО  
Б.БУЯНДЭЛГЭР  
Г.ТУУЛХҮҮ  
Ш.СОЛОНГО**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 2,25

**Индекс: 200003**